



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014. 06. 09 № 03/55 ЧАЛЖ/САЛЖ/2014/ЗГИМТ

Г Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2005 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлсэн авлагын үлдэгдэл 19,493,847,661.50 төгрөг байгаагаас 17,423,435,215.00 төгрөг нь 5 арилжааны банктай холбоотой авлага байна.

Аудитаар тооцоо нийлж баталгаажуулсан тооцооллыг шалгаж үзэхэд тухайн 5 банкинд 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлд гараагүй, гарсан зээлээс буцаан төлөгдсөн зэрэг нийт 11,704,138,833.27 төгрөг байна.

ОССК-ийн үйл ажиллагааг дуусгавар болгож, татан буулгах комисс томилогдсон, "40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд дахин зээлжүүлэлт гарагчий болсон зэргээс төсвийн хөрөнгө үр ашиггүй, бусад эх үүсвэрт зарцуулагдах эрсдэл үүсэх магадлалтай байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

"40000 орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцож, хөтөлбөрийн эх үүсвэрээс зээлд гараагүй үлдэгдлийг Улсын төсөвт төвлөрүүлж авлагыг барагдуулан, зээлд олгогдсон хэсэгт эргэн төлөлтийн хуваарь хийн гэрээг шинэчлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2014 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Б.Нямаад даалгав.

АХЛАХ АУДИТОР

УХА0122

Н.БАТСАЙХАН